

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 10 ДУГААР 17-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 10 дугаар сарын 25

Улаанбаатар хот

д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: Засгийн газрын 2022 оны 48 дугаар тэмдэглэлийн дагуу Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээний хийж, дүнг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн дотор ирүүлэх. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Газар зохион байгуулалтын алба, бусад хэрэгжүүлэгч агентлаг/				
1.	Дүүрэгт хамаарах Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, тайланг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 3/2618 тоот албан бичгээр Нийслэлийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар-ХОЁР: 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 16 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах. /Захирагчийн ажлын алба Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд/				
2.	Дүүргийн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 2022 оны 10 дугаар сарын байдлаар 96,4% байна. Үүнд: 1. Нийтлэг үйлчилгээний газар -98% 2. Боловсролын хэлтэс – 97% 3. Онцгой байдлын хэлтэс – 97,5% 4. Эрүүл мэндийн төв – 95% 5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв – 100%	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	<p>6. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6 - 88,5%</p> <p>7. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7 - 83,3%</p> <p>8. “Чингэлтэй Тохижилт үйлчилгээ” ХХК -100%</p> <p>9. “Найши трейд” ХХК -100%</p> <p>10. “Соёндрийм” ХХК -98%</p> <p>Хувийн халаалтын уурын зуухнууд:</p> <p>11. Ану сервис” ХХК -100%</p> <p>12. “Элбэг дулаан” ХХК -100%</p> <p>Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6: Дүүргийн 4, 5, 6, 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 110 байр, 645 аж ахуй нэгж байгууллагын халаалт, халуун хүйтэн усыг түгээж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ эрхэлдэг. Их засвараар нийт 6 нэр төрлийн 9 ажил, урсгал засвараар 18, нийт 27 нэр төрлийн ажил хийгдэхээр төлөвлөгдсөнөөс их засвар 83,3%, урсгал засвар 83%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7: Дүүргийн 1, 2, 3 дугаар хорооны 96 байрны 3405 өрх, 867 аж ахуй нэгж байгууллагын халаалт, халуун хүйтэн усыг түгээж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ эрхэлдэг. Их засвараар 6 нэр төрлийн ажил, урсгал засвараар 18 нэр төрлийн ажил нийт 24 ажил хийгдэхээр төлөвлөгдсөнөөс их засвар 89%, урсгал засвар 88%-ийн гүйцэтгэлтэй байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар ГУРАВ: Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэг нэмэгдүүлэх ажлаа эрчимжүүлж, борлуулалтын цэгүүдийг сайжруулсан түлшээр тасалдуулахгүй байхад анхаарах, түлшний чанар болон сайжруулсан шахмал түлш олгох картын системийн үйл ажиллагааг сайжруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зэрэг ажлуудаа эрчимжүүлж ажиллах. /Агаарын бохирдолтой тэмцэх газар, Дүүргийн Засаг дарга нар, Нийт байгууллагууд/</p>				
3.	<p>➢ Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2021-2022 оны өвөлжилтийн жилд үйл ажиллагаагаа 100 хувь үнэлүүлсэн нийт 78 сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгээс 75 цэгийн үйл ажиллагаагаа нээн ажиллаж байна. 2022-2023 оны халаалтын улиралд шинээр 22 сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгийг нээхээр болсон. 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 14 сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгийн гэрээг байгуулан үйл ажиллагааг нээн ажиллаж байна. Үлдсэн 8 сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгийг 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр гэрээг байгуулан үйл ажиллагаа хэвийн явагдана.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	90

	<ul style="list-style-type: none"> ➢ Сайжруулсан шахмал түлшний картыг 1560 айл өрхөд олгосон. Үүнээс шинээр олгосон 460, гэж үрэгдүүлсэн 1100 айл өрхөд карт олгоод байна. ➢ Чингэлтэй дүүргийн Засаг даргын А/288 дугаар захирамж болон Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах ажлын төлөвлөгөөний дагуу 7-20, 24 дүгээр хороодтой хамтран угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах талаарх 4 төрлийн нийт 17200 ширхэг тараах материалыг угаарын хийн хордлогот өртөх өндөр эрсдэлтэй айл өрхүүдэд тараан ажилласан. 			
Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Иргэдэд ая тухтай орчин бүрдүүлэх чиглэлээр дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт хийгдэх ногоон байгууламжийн байршлыг тодорхойлж нийслэлийн удирдлагуудад танилцуулах. /Дүүргийн Засаг дарга нар/				
4.	<p>Дүүргийн хэмжээнд ирэх онд ногоон байгууламж хийгдэх 3 байршил байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хоймор хайрхан амралт” ОНӨТҮГ 2. Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хайрхан хөгжлийн төв” ОНӨУТҮГ 3. Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Тахилтын ам “Бичил цэцэрлэгт хүрээлэн” байна. <p>Ногоон байгууламжийн байршлын талаарх мэдээлэл, судалгааг удирдлагуудад танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	50
Үүрэг, даалгавар ТАВ: Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхдийн тусламж, үйлчилгээ үзүүлж бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд бэлтгэл ажлаа сайтар хангах, эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлж ажиллах. /Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Дүүргийн Засаг дарга нар/				
5.	<p>2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> ➢ ЧЭМТ-ийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа нийт 178 өвчтөн байна. Үүнээс: хүүхдийн тасагт 100 хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. Хүүхдийн эрчимт эмчилгээнд 3 хүүхэд байна. <p>Хүүхдийн хүлээн авах яаралтай тусламжаар ирж үзүүлсэн-89, хэвтсэн-16, зөвлөгөө авч буцсан-73 хүүхэд байна.</p> <p>ЭМС-ын 2022 оны 7 сарын 18-ний өдрийн А/373 тушаалын дагуу томуугийн төлөвлөгөөг тодотгон хүүхдийн тасгийн орны ачаалал нэмэгдсэнтэй холбогдуулан мэдрэл, уламжлалтын тасгийг чөлөөлж хүүхдийн тасгийг 80 ороор нэмэгдүүлэн нийт 130 хүүхдийн ор дэлгэн ажиллаж байна.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	90

	<p>ЭМС-ын А/510 дугаар тушаалын дагуу амьсгалын замын халдвар нэмэгдсэнтэй холбоотой 1-6 дугаар хорооны хүүхдүүдийг ТТАХН эмнэлэгт, 7, 8, 9 хороодын хүүхдүүдийг ХӨСҮТ-д хэвтүүлэн эмчилж байна.</p> <p>НЭМГ-ын даргын А/208 дугаар тушаалын дагуу 7,8,9,10,12,15,17,18 дугаар хороодын дотрын тусламж үйлчилгээг СХД эмнэлэгт, мэдрэлийн яаралтай тусламж үйлчилгээг Улсын клиникийн нэгдүгээр төв эмнэлэг рүү тус тус шилжүүлсэн.</p> <p>НЭМГ-ын даргын А/207 дугаар тушаалын дагуу 2022 оны 10 сарын 19-ний өдрөөс эхлэн хүүхдийн үзлэгийн хүлээгдэл, чирэгдлийг бууруулах зорилгоор уртасгасан цагаар дүүргийн эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар хуваарийн дагуу эрүүл мэндийн төвд ажлын өдрүүдэд 17:00-21:00, амралтын өдрүүдэд 11:00-18:00, 18:00-22:00 цаг хүртэл 2 ээлжээр уртасгасан цагаар ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар ЗУРГАА: Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг анги, танхим, дотоод орчиндоо амны хаалт зүүлгэх зөвлөмж чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Боловсролын газар, Дүүргийн Засаг дарга нар/</p>				
6.	<p>Дүүргийн Ерөнхий боловсролын 21 сургууль, 40 цэцэрлэгийн эмч нарт томуу, томуу төст өвчний шинж тэмдэг илэрсэн хүүхдийг цэцэрлэг, сургууль дээр хүлээн авахгүй байх, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хандах хүүхдийг олноор цуглуулан өдөрлөг, уулзалт, тэмцээн, уралдаан зохион байгуулахгүй байх зэрэг чиглэлийг өгч ажиллалаа.</p> <p>Мөн 14 хоног тутам хүүхдүүдийн дунд ирцийн тандалт хийн, дүгнэлт, зөвлөмж өгөн ажиллаж байна.</p> <p>Улирлын томуугийн вакцинд хамрагдах ЕБС-ийн 4 болон 15 настай хүүхдүүдийн вакцинжуулалтад 4000 орчим хүүхэд хамрагдахаас 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 80%-ын хамрагдалтай байна. Томуу, томуу төстийн вакцинжуулалт цэцэрлэгийн 2-4 настай хүүхдэд хийгдэж эхэлсэн. Томуугийн эсрэг дархлаажуулалтыг Өрхийн эрүүл мэндийн төв, харьяа сургууль цэцэрлэгтэй хамтран зохион байгуулж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
<p>Үүрэг, даалгавар ДОЛОО: Нийтийн тээврийн автобусны буудлуудыг дүүргүүдэд шилжүүлэх тооцоо, судалгаа, санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах. /Нийтийн тээврийн газар, Дүүргийн Засаг дарга нар/</p>				
7.	<p>Дүүргийн өмчид бүртгэлтэй сүүдрэвч бүхий тохижилттой 7 автобусны буудал 7,10,12,18,19 хороодын нутаг дэвсгэрт байна.</p> <p>Дүүргийн 10, 11, 12, 13, 15, 16, 18, 19 дугаар хороодын нутаг дэвсгэрт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Автобусны буудлын тохижилт” төсөл арга хэмжээний хүрээнд 19 байршилд автобусны буудлын тохижилтын ажил</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70

<p>хийгдэхээс 9 байршлын гүйцэтгэл 100 хувьтай, 3 байршлын гүйцэтгэл 80 хувьтай, 4 байршлын ажлын гүйцэтгэл 50 хувьтай, 3 байршлын зураг төсөл зөвшилцөх шатандаа буюу 10 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Дүүргийн 16, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Автобусны буудлын тохижилт” төсөл арга хэмжээний хүрээнд 2 автобусны буудлын тохижилтын ажил, 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Автобусны буудлын тохижилт” төсөл арга хэмжээний хүрээнд 1 автобусны буудлын тохижилтын ажил бүрэн хийгдсэн.</p>			
---	--	--	--

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

М.НАВЧАА

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Х.ТУЯА